



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 327

Улаанбаатар хот

Г “Албан журмын даатгагчдын холбооны 7
дүрэм”-ийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 12¹.9 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д дор дурдсан өөрчлөлтийг оруулснаар зөвшөөрсүгэй:

1.1. Дүрмийн 3.6 дахь заалтыг “Удирдах зөвлөл дараах тохиолдолд Холбооны гишүүний албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Санхүүгийн зохицуулах хороонд уламжилна.”, дүрмийн 6.9.3 дахь заалтыг “Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрснөөр Холбооны гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх;” гэж өөрчлөн найруулах;

1.2. Дүрмийн 6.9.6 дахь заалтын “гишүүнээс хасах” гэснийг, 3.2, 3.6.4 дэх заалтыг хасах.

2. ”Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл/Г.Хэрлэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН